



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 23 өдөр

Дугаар 166

Мандалговь

Орон сууц хувьчлах тухай


Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Монгол улс н Орон сууц хувьчлах тухай хуулийн 16 дугаар зүйлийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Адаацаг сумын дунд сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй дотуур байрны 4 өрөө орон сууц, 4 айлын орон сууцны барилгыг хавсралт 1-ийн дагуу, Баянжаргалан сумын ЕБСургууль, Хүн эмнэлэг, ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн бүртгэлд буй 7 айлын орон сууцны барилгыг хавсралт 2-ын дагуу метр квадрат бүрийн үнийг 15 000 /арван таван мянга/ төгрөгөөр эзэмшигч тус бүрт нь худалдаж, хувьчлахыг зөвшөөрсүгэй.

2.Орон сууцнуудын худалдах үнийг одоогийн эзэмшигчдээс 2014 оны 3-р улиралд багтаан 100 хувь гаргуулж, Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Адаацаг сумын дунд сургуулийн захирал Л.Бадамханд, Баянжаргалан сумын ЗДТГ-ын дарга Т.Цэвэлмаа, ЕБС-ийн захирал С.Цэрэн-Янжин, Хүн эмнэлгийн салбарын эрхлэгч Н.Алтанцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоосон хугацаанд төлбөр нь хийгдээгүй байрыг дуудлага худалдаагаар худалдахыг Орон нутгийн өмчийн алба /П. Очирбат/-д даалгасугай.

4. Худалдсан орон сууцнуудыг хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Адаацаг сумын дунд сургуулийн захирал Л.Бадамханд, Баянжаргалан сумын ЗДТГ-ын дарга Т.Цэвэлмаа, ЕБС-ийн захирал С.Цэрэн-Янжин, Хүн эмнэлгийн салбарын эрхлэгч Н.Алтанцэцэг нарт тус тус даалгасугай.

ДАРГА  С. БУДЖАВ



2

Аймгийн ИТХТ-ийн 2014 оны 5 сарын  
23 өдрийн 16-р тогтоолын хавсралт 1

Адаацаг сумын хувьчлах орон сууц

№	Нэр	Одоо оршин сууж буй төрийн албан хаагч	Эрхэлж буй албан тушаал	Эзэмшсэн жил	Талбай /м <sup>2</sup> /	Худалдх үнэ
1	Дунд сургуулийн дотуур байр	Г.Долгормаа	Эх барих бага эмч	15	86.5	1 297 500 ✓
2		Л.Бадамханд	Сургалтын менежер	12	43.25	648 750 ✓
3		Д.Нацаг	Дотуур байрны жижүүр	18	43.25	648 750 ✓
4	Дунд сургуулийн 4 айлын орон сууц	С.Отгонбаатар	Сургуулийн галч	8	46	690 000 ✓
5		А.Должинсүрэн	Багш	11	46	690 000 ✓
6		Ж.Баттулга	Багш	18	46	690 000 ✓
7		Д.Батхурц	Багш	19	46	690 000 ✓
Нийт дүн						5 355 000

Аймгийн ИТХТ-ийн 2014 оны 05 сарын  
22 өдрийн 16-р тогтоолын хавсралт 2

Баянжаргалан сумын хувьчлах орон сууц

№	Эзэмшигч байгууллага	Одоо оршин сууж буй төрийн албан хаагч	Эрхэлж буй албан тушаал	Талбай /м <sup>2</sup> /	Худалдх үнэ
1	ЕБС	Ж.Батцэцэг	Бага ангийн багш	68	1 020 000 ✓
2		Н.Мөнхцэцэг	Гадаад хэлний багш	68	1 020 000 ✓
3	ЗДТГ	Д.Отгонсүрэн	Цагдаа	53	795 000 ✓
4	ЭМТөв	Н.Алтанцэцэг	Эрхлэгч эмч	56	840 000 ✓
5		А.Даваасүрэн	Сувилагч	56	840 000 ✓
6	ЗДТГ	Ж.Жамъяндор	Улсын бүртгэгч	56	840 000 ✓
7		Э.Сувд	ЖДҮ, ХХАА-н мэргэжилтэн	56	840 000 ✓
Нийт дүн					6 195 000